

“АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв (сая.т өг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэ лийн хувь
					Эхний хагас жил		
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах цалин хөлс нэмэгдэл, шагнал урамшуулал, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх:							
1	Албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тавилга эд хогшлоор хангаж, үе шаттай шинэчлэх;	-	Гүйцэтгэлийн хувь	-	100	Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Гүйцэтгэх захирлын баталсан А/04, А/23 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд шууд худалдан авалтыг зохион байгуулж, 24,379,80 төгрөгийн өртөг бүхий 17 ш техник, тоног төхөөрөмжийг шинэчилсэн.	100%
2	Албан хаагчдыг үдийн амралтын үеэр богино хугацаанд алжаал тайлах /цай, кофе уух, сонин сэтгүүл унших гэх мэт/ амрах өрөө тасалгаатай болгох;	-	Гүйцэтгэлийн хувь	-	100	Мөн албан хаагчдын амрах өрөөний тохижилтыг сайжруулах зорилгоор 1,299.9 төгрөгийн үнэ бүхий кофе найруулагч машинтай болгосон.	100%
3	Цалин, урамшууллын шатлалыг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, инфляцын төвшинтэй уялдуулан үе шаттай шинэчлэх;	-	Гүйцэтгэлийн хувь	-	-	Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар албан хаагчдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх саналыг хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	30%
4	Албан хаагчдын ур чадварын нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу олгох ажлыг зохион байгуулах;	-	Ур чадварын нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгосон албан хаагчдын тоо	-	-	1.2026 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар албан хаагчдын ур чадварын үнэлгээг сар бүр үнэлж, үнэлгээний үр дүнд нийт 62,422,868.0 төгрөгийн ур чадварын нэмэгдэл, урамшуулал олгосон.	100%
			ээлжийн амралт олгосон албан хаагчийн тоо	-	-	2.Гүйцэтгэх захирлын баталсан 2026 оны Б/05 дугаар тушаалаар албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг баталж, хуваарийн дагуу 2 албан хаагчид ээлжийн амралтыг олгосон.	
4 арга хэмжээний хэрэгжилт-82.5%							


Гурав. Албан хаагчдын сурч боловсрох, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үзлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх:							
1	Албан хаагчдыг ажлаас хөндийрүүлэхгүйгээр сургалтад тогтмол хамруулах, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, хичээл сургалттай үед нь цалинтай чөлөө олгох, төлбөрийг зохих хэмжээгээр хариуцах;	-	Гүйцэтгэлийн хувь	-	69	Тайлангийн хугацаанд албан хаагчид чадавхижуулах болон мэргэшүүлэх нийт 8 сургалтанд хамрагдсан. Үүнд: 1.Харилцаа хандлага, ёс зүй-2 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 39 албан хаагч 2.Архив, албан хэрэг хөтлөлт-3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 54 албан хаагч 3.Мэргэшүүлэх сургалтад: -Сошиал медиа контентын багц сургалтанд 3 албан хаагч (байгууллагаас нийт 1,950,000 төг зардал гаргасан) -"МоніCPA LEADERSHIP" академийн сертификатай сургалтанд 2 албан хаагч -Санхүүгийн суурь мэдлэгээ дээшлүүлэх "Тод санхүү академи"-ийн няравын чадавхижуулах сургалтад 1 албан хаагч буюу нийт 99 албан хаагч хамрагдсан.	100%
2	Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт 1 жил тутамд нэг удаа хамруулж, зардлыг байгууллага хариуцах;	-	Гүйцэтгэлийн хувь	-	100%	"Албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах тухай" гүйцэтгэх захирлын А/09 дүгээр тушаал батлагдаж, уг үзлэгийг 2026 оны 04 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулсан ба нийт 18 албан хаагч хамрагдсан.	100%
2 арга хэмжээний хэрэгжилт-100%							
Дөрөв. Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах, ажиллах идэвх санаачлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх:							
1	Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, албан хаагчдын ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	-	Ажлын цагийн уян хатан зохицуулалт хийсэн эсэх	-	-	-Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2026 оны 119 дүгээр тогтоол, НЗД-ын 2026 оны А/564 дүгээр захирамжийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2026 оны А/14 дүгээр тушаалын дагуу 2026 оны 05 дугаар 01-нээс 7 хоног бүрийн ажлын 1 өдрийг цахимаар ажил эхлэх цагийг 07:00-08:30, дуусах цагийг 16:00-17:30 цаг байхаар зохицуулсан. Цахимаар ажиллаж буй өдрийн ажлын цагийн бүтээмж, гүйцэтгэлд холбогдох нэгжийн удирдлага тухай бүр хяналт тавьж, үр дүнг Ерөнхий менежерт сар бүр танилцуулж ажиллаж байна. Мөн 3 хүртэлх насны хүүхэдтэй 2 албан хаагчдад ажлын цагийн уян хатан зохицуулалт бүхий ажлын байрны нөхцөлийг бүрдүүлж холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

		-	Чөлөө олгосон албан хаагчдын тоо	-	-	Тайлангийн хугацаанд 2 албан хаагч чөлөө хүссэн өргөдөл, хүсэлт гаргасны дагуу гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр тус бүр 10 хоногийн цалингүй чөлөө олгосон.	100%
		-	Албан хаагчид болон хүүхдүүдэд зориулсан арга хэмжээний тоо	-	1	Гүйцэтгэх захирлын А/21 дүгээр тушаалаар "Байгууллагын эцэг эхийн зөвлөл"-ийг байгуулж, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Тус зөвлөл нь Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр албан хаагчдын 46 хүүхэд багачуудад хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйл гардуулсан.	100%
		1 арга хэмжээний хэрэгжилт-100%					
Хагас жилийн гүйцэтгэлийн хувь		94,1%					

ТАНИЛЦСАН:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

ХЯНАСАН:
АЛБАНЫ ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХАРИУДСАН
АЖИЛТАН



Э.БҮТЭД-ЭРДЭНЭ

Г.СҮНЖИДМАА

Ц.ДУНГАРМАА